




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3621 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
11.2%



НИЙТ ХАДГАЛАМЖ
15.8 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
30.4 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
926.3 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
9%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **2.1%**,

Инфляци: 2020 онд: **6.6%**,

Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **-1%**

Инфляци: 2020 онд: **5.6%**,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.2%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 7-р сарын байдлаар (2465) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 331.9 хувь, зарлага 830.6 хувиар нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2465.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 564 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 20 төгрөгөөр өсөв.

Долоодугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 174.86 төгрөг буюу 6.6 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 20.15 төгрөг буюу 0.72 хувиар, өмнөх улирлаас 1.91 хувиар өсч 2,836.41 төгрөг болов. 7-р сард гадаад валютын нөөц 3.62 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 2 хувиар өсч, оны эхнээс 17 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 3.4%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 7-р сарын байдлаар өмнөх сараас 0.5 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар, оны эхнээс 3.3 хувь өсөв. Инфляцийн түвшин 2017 оны 7 дугаар сард 3.4 хувь, 2018 оны 7 дугаар сард 7.7 хувь, 2019 оны 7 дугаар сард 7.7 хувь гарч байсан бол 2020 оны 7 дугаар сард 3.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 4.3 пунктээр буурсан байна.




Гадаад худалдааны тэнцэл 846 сая.ам долларын ашигтай гарав.

2020 оны долоодугаар сард нийт барааны эргэлт 6730 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 17.1, импорт өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 846 сая ам.долларын ашигтай гарав.



7-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.mongolbank.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 7-р сард өмнөх сараас 0.2 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 0.5 хувиар өсч 17.3 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1944 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.4 хувиар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 0.5 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 11.2% байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 7 дугаар сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 129.5 (12.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 257.9 (29.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.6 хувийг эзэлж байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 7 дугаар сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 25.0 (1.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 10.9 (0.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

САРЫН ОНЦЛОХ

ГАДААД ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТ 22.6 ХУВИАР БУУРАВ.

- Манай улсын гадаад худалдааны эргэлт энэ оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 5.2 тэрбум ам.долларт хүрэв. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 22.6 хувиар буюу 1.5 тэрбум ам.доллар буурчээ. Мөн экспортоос 2.8 тэрбум ам.доллар төвлөрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 28.2 хувиар багассан үзүүлэлт аж. Экспорт буурахад чулуун нүүрсний борлуулалт 9.4 сая тоннор буюу 850.4 сая ам.доллароор багассан нь түлхүү нөлөөлжээ. Үүнээс гадна тайлант хугацаанд импортод 2.4 тэрбум орчим ам.доллар зарцуулсан нь 2019 оныхоос 1.1 тэрбумаар буюу 15 хувиар багассан дүн болов. Энэ оны эхний хагас жилд манай улс дэлхийн 138 оронтой худалдаа хийснээс 59-д бүтээгдэхүүн нийлүүлж, 131 орноос бараа импортлов. Экспортоос олсон орлого, импортод зарцуулсан хөрөнгөөс 368 сая ам.доллароор давж гадаад худалдааны тэнцэл эерэг гарчээ.

"ФИТЧ", "СТАНДАРД ЭНД ПҮҮРС" АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ХЭВЭЭР ҮЛДЭЭВ.

- 2020 оны I улирлын байдлаар манай улсын гадаад өр 19.8 тэрбум ам.доллар буюу 2019 оны ДНБ-ийн 143 орчим хувьтай тэнцэж байна. Нийт өрийн бүтцээс харахад 36.5 хувь нь Засгийн газрын өр, 10 хувь нь Төв банкны өр, 53.5 хувь нь хувийн хэвшлийн өр төлбөр эзэлж байгаа юм. Өмнө дурдсанчлан Монголбанк Хятадын Ардын банкттай байгуулсан төгрөг-юанийн своп хэлцлийг дахин 3 жилээр сунгах тохиролцоонд хүрсэн. "COVID-19"-ийн цар тахлын нөлөөгөөр дэлхий дахинд Төв банкууд мөнгөний зөөлөн бодлого баримталж байгаа тул олон улсад хүүгийн түвшин тогтвортой буурч, санхүүжилтийн өртөг, зардал хямдарсаар байна. Мөн олон улсын зэрэглэл тогтоогч "Фитч", "Стандарт энд Пүүрс" агентлаг Монгол Улсын эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдлыг харгалзан, зээлжих зэрэглэлийг хэвээр буюу "В", төлөвийг "тогтвортой" хэмээн үнэлэв.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 7-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 7-р сар 2020 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn